

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 55 дугаар зүйлийн 55.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Сангийн сайдын 2023 оны А/258 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг” (цаашид “жишиг баримт бичиг” гэх)-т “Тендер шалгаруулалтын зарлал”-ыг нэгдүгээр хавсралт ёсоор болон 1 дүгээр бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 21.8 дахь заалтын “маягтад” гэсний дараа “заасан” гэж, 5 дугаар бүлгийн нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтын 6 дугаар маягтын “үндэслэл” гэсний дараа “, тайлбар” гэж тус тус нэмсүгэй.

2.Жишиг баримт бичгийн 4 дүгээр бүлгийн 4.1 дэх “Чанар ба үнийн хосолмол” тендер үнэлэх үндсэн шалгуурыг хоёрдугаар хавсралт ёсоор болон 2 дугаар бүлгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1 дэх заалтыг “Оролцогчид тавих санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлага: [“Шаардлагатай” эсхүл “Шаардлагагүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардлагатай бол хуулийн 15 дугаар зүйлд үндэслэн холбогдох шаардлага, мэдээллийг тодорхой бичих.]” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.2 дахь заалтыг “Зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол бараа нийлүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ олгодог байгууллага, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээний нэрийг тодорхой бичих]” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1 дэх заалтын хашилт доторх өгүүлбэрийг ““Тийм” гэж хариулсан бол санхүүгийн чадавхтай холбоотойгоор хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож шаардаж болох ба бусад баримт бичиг шаардахыг хуулиар зөвшөөрөөгүй болохыг анхаарна уу.” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1 дэх заалтын хашилтын дараах өгүүлбэрийг “[“Тийм” гэж хариулсан бол техникийн чадавх, туршлагатай холбоотойгоор хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан болон 17.4-т хамаарах баримт бичгээс сонгож шаардаж болно. Шаардсан бол V бүлгийн холбогдох маягыг бөглөж ирүүлнэ.]” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 25.5 дахь заалтыг “Оролцогчдод ил болгох нэмэлт баримт бичгийн жагсаалт: [Оролцогчоос тендерт ирүүлэхээр өгөгдлийн хүснэгтэд заасан баримт бичгээс ил болгох шаардлагатай бол заах]” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

3.Жишиг баримт бичгийн 1 дүгээр бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 12.1 дэх заалт, 3 бүлгийн бараа нийлүүлэлтийн хуваарийн хашилт доторх “тендерт оролцогч” гэснийг “оролцогч” гэж, 6 дугаар бүлгийн гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 3.8 дахь заалтын “Тендерт оролцогч” гэснийг “Оролцогч” гэж, 1 дүгээр бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 13.2.7 дахь дэд заалт, 4 дүгээр бүлгийн “Жишээ нь: А4 бичгийн цаас худалдан авах үнэлгээний шалгуур үзүүлэлт” хэсгийн “тендерт оролцогчийн” гэснийг “оролцогчийн” гэж, 1 дүгээр бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 11.1 дэх заалтын “6.6-д” гэснийг “6.4-т” гэж, тендер шалгаруулалтын зааварчилгааны 16.4 дэх заалтын “14.2, 14.3” гэснийг “16.2, 16.3” гэж, тендер шалгаруулалтын зааварчилгааны 35.3 дахь заалтын “33.2” гэснийг “35.2” гэж, 2 дугаар бүлгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 1.1 дэх

заалтын “Тендерийн урилгын” гэснийг “Тендер шалгаруулалтын зарлалын” гэж, мөн заалтын хашилт доторх “урилгын” гэснийг “зарлалын” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 8.1 дэх заалтын “8.1” гэснийг “10.1” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1 дэх заалтын “Маягт 6-ын” гэснийг “Маягт 4-ийн” гэж, өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 29.2 дахь заалтын “хэрэгсэл” гэснийг “хэрэглэгдэхүүн” гэж, 4 дүгээр бүлгийн гарчгийн “Тендерийн үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлтүүд” гэснийг “Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт” гэж, мөн бүлгийн 4.2 дахь “Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт” хэсгийн “29.1-д”-д гэснийг “29.2-т” гэж, 5 дугаар бүлгийн тендер илгээх 1 дүгээр маягтын 5 дахь заалтын хашилт доторх “30 ба түүнээс дээш хоногийн тоо” гэснийг “ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо” гэж, мөн заалтын “хоногийн” гэснийг “өдрийн” гэж, 6 дугаар бүлгийн гэрээний ерөнхий нөхцөлийн 2.17 дахь заалтын “тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6” гэснийг “өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 21.6” гэж, гэрээний ерөнхий нөхцөлийн 3.8 дахь заалтын “40.4-д” гэснийг “40.1.2-т” гэж, гэрээний ерөнхий нөхцөлийн 4.12 дахь заалтын “43.7” гэснийг “42.6” гэж, гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 2.17 дахь заалтын “20.6-ийн” гэснийг “21.6-ын” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Жишиг баримт бичгийн 1 дүгээр бүлгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.3 дахь заалтын “өгөгдлийн хүснэгтэд зааснаар” гэснийг, тендер шалгаруулалтын зааварчилгааны 21.9 дэх заалтын “тендер шалгаруулалтын” гэснийг, 2 дугаар бүлгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1 дэх заалтын “нэмэлт” гэснийг, 4 дүгээр бүлгийн барааны үнийн задаргааны 2 дугаар маягтын 3 дугаар баганын “Гарал үүслийн улс” хэсгийн 2 дугаартай зүүлт тайлбарыг тус тус хассугай.

5.Энэ тушаалыг холбогдох журмын дагуу бүртгүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Ганбат), Хууль, эрх зүйн газар (З.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

Сангийн сайдын 2025 оны ... дүгээр сарын
...-ны өдрийн ... дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **[тендер шалгаруулалт зарласан он, сар, өдрийг бичих]**
Тендер шалгаруулалтын төрөл: Бараа
Тендер шалгаруулалтын нэр: **[төсөл, арга хэмжээний батлагдсан нэрийг бичих]**
Тендер шалгаруулалтын дугаар: **[цахим системд заасан тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**
Нийт төсөвт өртөг: **[нийт төсөвт өртгийг бичих]**
Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

1. **[Захиалагчийн нэрийг бүрэн, товчлохгүйгээр бичих]** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **[Хэрэв багцтай бол “Тийм”, багцгүй бол “Үгүй”]**

Багц № 1: багцын нэр,
Багц № 2: багцын нэр...гэх мэт.

Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бичих:

Дотоодын багц № 3: багцын нэр,
Дотоодын багц № 4: багцын нэр...гэх мэт.

3. Тендерийг **[тендер хүлээн авах огноо, цаг]**-аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар ирүүлэх ба тендерийн нээлтийг [огноо]-ны өдрийн, [цаг]¹-т худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулна.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **[“Зөвшөөрнө” эсхүл “Зөвшөөрөхгүй” гэдгийн аль нэгийг сонгоно уу]**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **[“Эрхтэй” эсхүл “Эрхгүй” гэдгийн аль нэгийг сонгоно уу]**
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **[“Тийм” эсхүл “Үгүй”]** Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичигт заасан үнийн дүн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **[“Тийм” эсхүл “Үгүй”]**

¹ Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: ***["Туйм" эсхүл "Үгүй"]***
10. Сонирхогч этгээд цахим системээр тендер шалгаруулалтын баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

[Захиалагчийн тодорхой хаяг, утас/цахим шуудангийн хаяг]

IV.1. “Чанар ба үнийн хосолмол” тендер үнэлэх үндсэн шалгуур

Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн худалдан авах чанар ба үнийн хосолмол шалгуур
(Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн худалдан авах тендер шалгаруулалтаас
бусад тендер шалгаруулалтад тус тендер үнэлэх үндсэн шалгуурыг
тендер шалгаруулалтын баримт бичгээс хасна)

1. Эмийн чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:
 - 1.1. Үйлдвэрлэгч улсын төлөвшлийн түвшин² 4-т багтсан 15 оноо
улсад үйлдвэрлэгдсэн бол: эсхүл

Үйлдвэрлэгч улсын төлөвшлийн түвшин 3-т багтсан 10 оноо
улсад үйлдвэрлэгдсэн бол:

1.2. Эм нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын 15 оноо
эмийн зохицуулалтын үнэлгээгээр хүлээн зөвшөөрөгдсөн (WHO-listed-authority /WLA/) эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай улсад үйлдвэрлэгдсэн бол:³ эсхүл 5 оноо

ДЭМБ-ын эмийн зохицуулалтын үнэлгээгээр шилжилтийн жагсаалтад байгаа улсад үйлдвэрлэгдсэн бол:⁴

1.3. Эм нь үйлдвэрлэгч улсдаа хэрэглэгддэг бол: 5 оноо
(Тайлбар: Тухайн эмийн CoPP баримт бичгийг тендер шалгаруулалтын баримт бичигт шаардан авч, түүнээс харах);

1.4. Анхдагч эм бол: эсхүл 15 оноо

Ерөнхий нэршлийн эмийн хувьд биоэквивалент чанарын судалгааг хөндлөнгийн эрх бүхий судалгааны байгууллагаар хийлгэхэд эмчилгээний явцуу хүрээний эм бол (Цусан дахь эмийн идэвхт бодисын хамгийн их концентраци (C_{max}) 90-110%, Бусад нэршлийн эм нь (C_{max}) 80-125%): 15 оноо
(Тайлбар: Тухайн эмийн судалгааны тайланг тендер шалгаруулалтын баримт бичигт шаардан авч, түүнээс харах);

1.5. Эм, эмийн үндсэн үйлчлэгч бодисыг итгэмжлэгдсэн 15 оноо
хөндлөнгийн лабораторийн шинжилгээнд Англи, АНУ, Европ, Япон, БНХАУ, ОХУ, БНСУ гэсэн улсуудын аль нэг улсын фармакопейн дагуу хамруулж, шаардлага хангасан бол:
(Тайлбар: Тухайн эмийн эцсийн бүтээгдэхүүний шинжилгээний бичиг болон үндсэн үйлчлэгч бодисын

² www.efaidnbmnnnibpcajpcgclclefindmkaj/https://cdn.who.int/media/docs/default-source/medicines/regulatory-systems/wla/list эх сурвалжаас хянан үзэх.

³ <https://www.who.int/initiatives/who-listed-authority-reg-authorities> эх сурвалжаас хянан үзэх.

⁴ www.efaidnbmnnnibpcajpcgclclefindmkaj/https://cdn.who.int/media/docs/default-source/medicines/regulatory-systems/wla/list-of-transitional-wla эх сурвалжаас хянан үзэх.

шинжилгээний бичгийг тендер шалгаруулалтын баримт бичигт шаардан авч, шинжилгээний бичгээс Англи, АНУ, Европ, Япон, БНХАУ, ОХУ, БНСУ гэсэн улсуудын аль нэг улсын фармакопейн шинжилгээний аргаар шинжилгээг хийсэн эсэхийг лавлаж харах);

- 1.6. Оролцогч нь тухайн эмийг өөрөө импортолсон бол: 5 оноо

(Тайлбар: Тендер шалгаруулалтын баримт бичигт тухайн эмийн импортын мэдүүлгийг шаардан авч, түүнээс харах).

Нийт: 70 оноо

2. Эмнэлгийн хэрэглэгдэхүүний чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:

- 2.1. Үйлдвэрлэгч нь ISO 13485 стандартын шаардлага хангасан бол: 20 оноо

- 2.2. Импортын эмнэлгийн хэрэглэгдэхүүн үйлдвэрлэгч улсдаа бүртгэл (бүртгэлтэйг нотолсон баримт бичгийг албан ёсны байгууллагаар баталгаажуулж, өөр улсын хэл дээр бол англи хэлээр орчуулсан байх)-тэй бол: 20 оноо

- 2.3. Эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг эрх бүхий байгууллага (SGS, Bureau Veritas, Intertek, Dekra SE, TUV SUD, TUV RHEINLAND)-аас холбогдох стандарт, дүрэм, журамд нийцүүлж буй баталгаажуулсан гэрчилгээтэй бол: 15 оноо

- 2.4. Импортын эмнэлгийн хэрэглэгдэхүүн нь үйлдвэрлэгч улсаас экспортлох зөвшөөрөл (Free Sale Certificate)-тэй бол: 15 оноо

Нийт: 70 оноо

3. Дотоодын үйлдвэрийн эмийн чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:

- 3.1. Үйлдвэрлэгч нь ISO 9001 стандартын шаардлага хангасан бол: 10 оноо

- 3.2. Үйлдвэрлэгч нь GMP стандартын шаардлага хангасан бол: 25 оноо

- 3.3. Тохирлын гэрчилгээтэй бол: 5 оноо

- 3.4. Эм нь итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторийн шинжилгээнд хамруулж, шаардлага хангасан бол: 15 оноо

- 3.5. Түүхий эдийн шинжилгээний бичиг дээр Европын фармакопейн шаардлага хангасан бол: эсхүл 15 оноо

(Тайлбар: Хольцын үзүүлэлтийг заавал тодорхойлсон шинжилгээний дүнг тендер шалгаруулалтын баримт бичигт шаардаж, хянан үзэх)

Англи, АНУ, Япон, БНХАУ, ОХУ, БНСУ гэсэн улсуудын аль нэг улсын фармакопейн дагуу шинжлэгдсэн бол: 10 оноо

Нийт: 70 оноо

4. Дотоодын үйлдвэрийн эмнэлгийн хэрэглэгдэхүүний чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:

- | | | |
|------|--|---------|
| 4.1. | Үйлдвэрлэгч нь ISO 9001 стандартын шаардлага хангасан бол: | 10 оноо |
| 4.2. | Үйлдвэрлэгч нь ISO 13485 стандартын шаардлага хангасан бол: | 20 оноо |
| 4.3. | Тохирлын гэрчилгээтэй бол: | 10 оноо |
| 4.4. | Эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторийн шинжилгээнд хамруулж, шаардлага хангасан бол: | 30 оноо |

Нийт: 70 оноо

5. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн худалдан авах тендер шалгаруулалтын үед хамгийн бага харьцуулах үнэ (P_{min})-тэй тендерт 30 оноо (S_{max}) өгч, бусад оролцогчийн харьцуулах үнэ (P_x)-д харгалзах оноог дараах томъёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \times S_{max}$$

- | | | |
|-----------|---|---|
| P_{min} | - | Хамгийн бага харьцуулах үнэтэй оролцогчийн үнэ |
| P_x | - | Тухайн оролцогчийн үнэ |
| S_{max} | - | Хамгийн бага харьцуулах үнэтэй оролцогчийн оноо |
| S_x | - | Тухайн оролцогчийн оноо |

6. Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурт нийт оноог дээрх аргачлалын дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.

$$B_x = Q_x + S_x$$

- | | | |
|-------|---|---|
| B_x | - | Тухайн оролцогчийн чанар ба үнийн харьцуулалтын нийт оноо |
| Q_x | - | Тухайн оролцогчийн чанарын үнэлгээний оноо |